

Төрийн албаны зөвлөлийн
2024 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн
08:44 дүгээр тогтоолын 07 дүгээр хавсралт

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

- Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан
 Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай
хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай
хууль (2023.01.06)

Дагаж мөрдөх огноо:

2023.03.01

Албан тушаалын тодорхойлолтыг
баталсан огноо:

24 06 27

Байгууллагын нэр:

Нэгжийн нэр:

Гадаадын иргэн, харьяатын газар

Иргэний харьяаллын газар

Албан тушаалын нэр:

Албан тушаалын ангилал, зэрэглэл

Харьяат хариуцсан ахлах мэргэжилтэн

Дэс түшмэл, ТТ-6

Ажлын цаг:

Ажлын байрны албан ёсны байршил:

Ажлын өдрийн 8 цаг

Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, Буюнт-
Ухаа дэнж, Гадаадын иргэн, харьяатын
газрын төв байр

Хөдөлмөрийн нөхцөл:

Онцгой нөхцөл:

Хэвийн

Албан ажлын онцгой нөхцөлд хамаарна.

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Хууль тогтоомж, байгууллагын стратеги төлөвлөгөө, зорилт чиг үүргийн хүрээнд гадаадын
иргэний талаар төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэх, удирдлагыг мэдээллээр хангах чиг
үүргийг хэрэгжүүлж, гүйцэтгэлийн үр дүнг нэгжийн даргын өмнө хариуцна.

Албан тушаалын зорилт:

1. Монгол Улсын иргэний харьяаллын асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах, эрх бүхий дээд байгууллага, албан тушаалтанд уламжилж, шийдвэрлүүлэх, иргэний харьяалал, хүүхэд үрчлэлт, төрийн бус байгууллагын талаарх тоон мэдээллийг нэгтгэх, судалгаа шинжилгээ хийж, салбарын бодлого, үйл ажиллагааны санал боловсруулж, эрх бүхий дээд байгууллага, албан тушаалтанд уламжлах;
2. Гадаадын иргэн Монгол Улсын харьяат хүүхэд үрчлэн авах, олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газраас ирүүлсэн хүсэлт, үйл ажиллагаанд хяналт тавьж, шийдвэрлүүлэх, холбогдох байгууллага, албан хаагчдад мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх;
3. Хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.

| | | | |
|---------------------------|--|---|---|
| Зорилт | Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг | Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт | Хариуцлага, оропцооны хэлбэр Туслах-Т Гүйцэтгэх-Г Хянах-Х Шийдвэрлэх -Ш |
| 1 дүгээр зорилтын хүрээнд | <p>1. Монгол Улсын харьяат болох, иргэний харьяаллыг сэргээн тогтоох, харьяатаас гарах үйл ажиллагаатай холбоотой албан бичгийн төсөл, удирдамж, илтгэх хуудас, танилцуулга, ярилцлагын тэмдэглэл, хүсэлт гаргагчийн талаарх дүгнэлт зэргийг хянаж, санал өгөх;</p> <p>2. Иргэний харьяаллын асуудлаар гарсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигийг тухай бүр холбогдох байгууллага, нэгжийн албан хаагчдад мэдэгдэж, хэрэгжилтийг хангах;</p> <p>3. Гадаадын болон өөрийн орны иргэдийг хоёрдмөл харьяалал үүсгэсэн эсэхийг шалгах, бүртгэл мэдээллийг хөтөлж, судалгаа шинжилгээ хийх ажлыг зохион байгуулах;</p> <p>4. Монгол Улсын харьяат болох, харьяатаас гарах, иргэний харьяаллаа сэргээн тогтоолгох, хоёрдмөл харьяалал, хүүхэд үрчлэлт, олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газрын мэдээллийг нэгтгэх, судалгаа, шинжилгээний дүн, авах арга хэмжээний саналыг удирдлагад тухай бүр танилцуулж, салбарын бодлого үйл ажиллагааны чиглэлээр хуулийн төсөл, холбогдох журмын санал боловсруулж, эрх бүхий дээд байгууллага, албан тушаалтанд уламжлах;</p> | <p>Хууль тогтоомжид нийцсэн байна.</p> <p>Хууль тогтоомжид нийцсэн байна.</p> <p>Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо, үр дүн</p> <p>Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо, үр дүн</p> | <p>X, Г</p> <p>Г</p> <p>Г, Х</p> <p>Г, Х</p> |



1119282407
ТУ31614 8_512895-01

| | | | |
|---------------------------|--|---|------|
| | 5. Иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн хүсэлтийн дагуу иргэний Монгол Улсын харьяат болсон, харьяатаас гарсан, иргэний харьяаллаа сэргээн тогтоолгосон талаарх лавлагаа, тодорхойлолт олгох ажлыг зохион байгуулж, хяналт тавих. | Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо, үр дүн | Г, Х |
| 2 дугаар зорилтын хүрээнд | 1. Гадаадын иргэн Монгол Улсын харьяат хүүхэд үрчлэн авах, олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газарт зөвшөөрөл олгох, хугацааг сунгах, хүчингүй болгох гэрчилгээнд нэмэлт өөрчлөлт оруулах, нэр солих зэрэг үйл ажиллагаатай холбоотой албан бичгийн төсөл, удирдамж, илтгэх хуудас, танилцуулгыг хянах; | Хууль тогтоомжид нийцсэн байна. | Г, Х |
| | 2. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн хүсэлтийн дагуу олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газрын талаарх лавлагаа, тодорхойлолт олгох ажлыг зохион байгуулах, хяналт тавих; | Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо, үр дүн | Г, Х |
| | 3. Иргэний харьяалал, хүүхэд үрчлэлт, олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газрын талаар бүртгэл, мэдээллийн санд үнэн зөв мэдээлэл, баримт нотолгоонд тулгуурлан оруулах ажлыг зохион байгуулах, хяналт тавих; | Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо, үр дүн | Х, Г |
| | 4. Бүртгэл, мэдээллийн санг боловсронгуй болгох, олон улсын жишигт нийцсэн мэдээллийн сан бий болгох, судалгаа шинжилгээ хийх, арга хэмжээг авч хэрэгжүүлэх; | Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо, үр дүн | Г |
| | 5. Монгол Улсаас гадаад улсад суугаа дипломат төлөөлөгчийн болон консулын газар, нэгжийн болон хилийн боомт, орон нутаг дахь газар хэлтсийн албан хаагчдад мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх; | Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо, үр дүн | Г |
| | 6. Хариуцсан чиг үүргийн хурээнд үйлчлүүлэгчдийг үнэн зөв, бодитой зөвлөгөө, мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах. | Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо, үр дүн | Г, Х |
| | 1. Төрийн албаны тухай, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай, Хөдөлмөрийн тухай, Захиргааны ерөнхий, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай, | Хууль тогтоомжид нийцсэн байна. | Г |

| | | | |
|---------------------------|---|--|---|
| З дугаар зорилтын хүрээнд | Харьяатын тухай, Монгол Улсын хилийн тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай, Зөрчлийн тухай, Төрийн болон албаны нууцын тухай, Архивын тухай, Нийтийн албанад, нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, байгууллагын "Хөдөлмөрийн дотоод журам" болон бусад хуульд тогтоомжид заасан чиг үүргийг хэрэгжүүлэх; | | |
| | 2. Эрхэлсэн ажлын чиг үүргийн хэрэгжилтийг бүрэн хариуцаж, зөрчил дутагдал гарсан тохиолдолд хариуцлага хүлээх; | Хууль тогтоомжид нийцсэн байна. | Г |
| | 3. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийг сахиж, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомж, стандартыг биелүүлэх; | Хууль тогтоомжид нийцсэн байна. | Г |
| | 4. Хөрөнгө орлогын мэдүүлгээ хуульд заасан хугацаанд үнэн зөв тайлagnах; | Хууль тогтоомжид нийцсэн байна. | Г |
| | 5. Архив, албан хэрэгт хөтлөлтийн стандартад нийцсэн баримт бичгийн төсөл боловсруулах, иргэн аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдол мэдээллийг хугацаанд нь шийдвэрлэх; | Хууль тогтоомжид нийцсэн байна. | Г |
| | 6. Иргэн, аж ахуйн, нэгж байгууллагыг хариуцсан ажлын чиглэлээр үнэн зөв бодитой мэдээллээр хангах, арга зүйн зөвлөгөө өгөх; | Хууль тогтоомжид нийцсэн байна. | Г |
| | 7. Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж, батлуулах, хэрэгжилтийг хангах, тайлagnах; | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь, Үнэлгээ | Г |
| | 8. Байгууллагаас зохион байгуулж буй олон нийтийн арга хэмжээнд идэвхтэй оролцох; | Оролцсон арга хэмжээний тоо | Г |
| | 9. Удирдлагаас өгсөн хууль ёсны үүрэг даалгаврыг биелүүлэх. | Гүйцэтгэлийн хувь | Г |

III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

| | |
|-----------|---|
| Боловсрол | Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй. |
| Мэргэжил | -эрх зүй (0421); -менежмент ба удирдахуй (0413); -олон улсын харилцаа (031202). |




| | |
|-----------|--|
| Мэргэшил | - |
| Туршлага | Туслах түшмэлийн албан тушаалд ажилласан бол давуу тал болно. |
| Ур чадвар | Дүн шинжилгээ хийх |
| | <ul style="list-style-type: none"> - баримт бичигт дүн шинжилгээ хийх, үнэлэлт, дүгнэлт өгөх чадвартай байх; - судалгааны арга зүйн мэдлэгтэй байх; - мэдээлэл дэх дутуу, алдаатай, нийцтэй бус байдлыг илрүүлэх; - гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах; - албан тушаалын чиг үүргээ хэрэгжүүлэхэд учирч болзошгүй эрсдэлийг урьдчилан тооцох, бууруулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх; - нэгжийн дотоод хяналтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд оролцох, үр дүнг тайлагнах; - бусад. |
| | Асуудал шийдвэрлэх |
| | <ul style="list-style-type: none"> - Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулийг чандлан баримталж, үндэсний язгуур ашиг сонирхолд захирагдан ард түмэндээ үйлчлэх; - албан тушаалын бүрэн эрхийн хүрээнд хуульд нийцсэн, оновчтой шийдвэрийг шуурхай гаргах; - асуудлыг хууль тогтоомж, ёс зүйн зарчимд нийцүүлэн ашиг сонирхлоос ангид шийдвэрлэх; - гаргасан шийдвэрийнхээ талаар хариуцлага хүлээх; - бусад. |
| | Багаар ажиллах |
| | <ul style="list-style-type: none"> - өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонгийн хуваалцаж хамтран ажиллах, үлгэрлэн манлайлах; - бусадтай харилцан итгэл төрүүлэхүйц ажил хэрэгч харилцаа бий болгох; - ажил хэрэгч, бүтээлч, санаачилгатай ажиллах; - хувийн зохион байгуулалт, ажлын цаг ашиглалтын хувьд бусдыг манлайлах; - бусад. |
| | Бусад |
| | <ul style="list-style-type: none"> - албан хэрэг хөтлөх, бодлогын баримт бичиг боловсруулах; - англи хэл, эсхүл бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийг ашиглах; - компьютерын хэрэглээний программ, мэдээллийн технологийн дэвшилтэт аргыг ашиглах; - бусдад хүндэтгэлтэй, соёлтой, адил тэгш хандах. |

IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЬЕКТ

Албан тушаалыг шууд харьялан удирдах албан тушаалын нэр:

Иргэний харьяалын газрын дарга

| | |
|--|--|
| <u>Албан тушаалд шууд харьялан удирдуулах албан тушаалын нэр, тоо:</u> | <u>Бусад харилцах субъект:</u> |
| | <ul style="list-style-type: none"> - Гадаад орон, олон улсын байгууллага, тэрийн бус байгууллага; - Иргэн, хуулийн этгээд, мэргэжлийн байгууллага.  |

V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

1119282307
ТУ31614 X 91289561

| | |
|--|---|
| Албан тушаалын тодорхойлолт боловсруулсан: | Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр: |
| Албан тушаал: ЗАХИРГЛАА УДИРДЛАГЫН ГАЗРЫН ДАРГА И.БААТАРХҮҮ 2024 оны 06 сарын 19 -ны өдөр 1116126983 2712253 | Байгууллагын нэр: ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ Шийдвэрийн огноо: 24.06.19 Дугаар: 284 |
| Албан тушаалын тодорхойлолтыг баталсан: | |
| Байгууллагын нэр: ГАДААДЫН ИРГЭН ХАРЬЯАТЫН ГАЗАР Шийдвэрийн огноо: 20.06.27 Дугаар: А/257 (тамга/тэмдэг) | ДАРГА..... Н.УУГАНБАЯР (Гарын үсэг) (Эцэг/эх-/ийн нэр, өөрийн нэр) 2024 оны 06 дугаар сарын 27 -ны өдөр |

